



МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/72

Баруун-Урт сум

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 11.2.6, 19 дүгээр зүйлийн 19.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7, Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны 10/3559 тоот дүгнэлт, Сүхбаатар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/39 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт “Энх хамар” нэртэй талбайд байрших

- |      |                 |               |
|------|-----------------|---------------|
| 1.1. | 113° 9' 13.15"  | 46° 47' 21.8" |
| 1.2. | 113° 10' 10.15" | 46° 47' 21.8" |
| 1.3. | 113° 10' 10.15" | 46° 48' 22.5" |
| 1.4. | 113° 9' 35.9"   | 46° 48' 22.5" |
| 1.5. | 113° 9' 35.9"   | 46° 47' 49.6" |
| 1.6. | 113° 9' 13.15"  | 46° 47' 49.6" |

дугаар солбилцол бүхий 177.51га талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг “Хаан шороо” ХХК-д 3 жилийн хугацаатай олгосугай.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг газрын мэдээллийн санд тусгаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Төгөлдөр)-т даалгасугай.

4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон талбайд явуулж буй үйл ажиллагаанд нь хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн хяналт шалгалтын тасаг (Г.Сугараа), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ш.Нямхүү), Сүхбаатар сумын Засаг дарга (Б.Батхүрэл), нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ

2224010165